



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 22 (499)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- *Төрийн өмчөөс аймаг, нийслэлийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх, орон нутгийн өмчийн зарим эд хөрөнгийг төрийн өмчид хүлээн авах тухай*

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- *Их эзэн Чингис хааныг дээдлэн хүндэтгэх, зарлигласан онол сургаалиас нь суралцах, түүний хөшөө, Төрийн ёслол хүндэтгэлийн өргөө цогцолборт төрийн хүндэтгэл үзүүлж байх тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2007 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2007 оны зургадугаар сарын 14

№22 (499)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- | | | | |
|------|---|-----------|-----|
| 263. | Төрийн өмчөөс аймаг, нийслэлийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх, орон нутгийн өмчийн зарим эд хөрөнгийг төрийн өмчид хүлээн авах тухай | Дугаар 37 | 506 |
|------|---|-----------|-----|

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- | | | | |
|------|---|------------|-----|
| 264. | Зэвсэгт хүчний зарим офицер, ахлагч нарыг медалиар шагнах тухай | Дугаар 96 | 510 |
| 265. | "Нээлттэй хаалганы өдөр"-ийг зохион байгуулж байх тухай | Дугаар 97 | 512 |
| 266. | Их эзэн Чингис хааныг дээдлэн хүндэтгэх, зарлигласан онол сургаалиас нь суралцах, түүний хөшөө, Төрийн ёслол хүндэтгэлийн өргөө цогцолборт төрийн хүндэтгэл үзүүлж байх тухай | Дугаар 98 | 513 |
| 267. | БНСУ-ын зарим иргэнийг одон, медалиар шагнах тухай | Дугаар 99 | 514 |
| 268. | Дэмбэрэлийн Чойжамцад Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай | Дугаар 100 | 514 |
| 269. | Чойжилжавын Дамбажавт Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай | Дугаар 101 | 515 |
| 270. | Зарим хүмүүсийг сум дундын шүүхийн ерөнхий шүүгчийн албан тушаалд томилуулах тухай | Дугаар 124 | 515 |
| 271. | Зарим хүмүүсийг шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай | Дугаар 125 | 515 |
| 272. | Зарим хүмүүсийг аймаг, сум дундын болон нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн шүүгчийн албан тушаалд томилуулах тухай | Дугаар 126 | 516 |
| 273. | Шүүгчийг сэлгэн ажиллуулах тухай | Дугаар 127 | 516 |
| 274. | Т.Эрдэнэбаатарыг шүүгч, ерөнхий шүүгчийн албан тушаалаас огцруулах тухай | Дугаар 128 | 516 |

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- | | | | |
|------|---|------------|-----|
| 275. | Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх төлөвлөгөө батлах тухай | Дугаар 61 | 516 |
| 276. | Эрүүл мэндийг дэмжих сангийн дүрэм, сангийн зөвлөлийн бүрэлдэхүүн, зөвлөлийн ажиллах журам батлах тухай | Дугаар 92 | 523 |
| 277. | Ажилд томилох тухай | Дугаар 100 | 526 |
| 278. | Зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчний тархалтыг бууруулах ажлыг эрчимжүүлэх тухай | Дугаар 102 | 526 |
| 279. | Ажилд томилох тухай | Дугаар 105 | 527 |
| 280. | Ажилд томилох тухай | Дугаар 106 | 527 |
| 281. | Нарны цахилгаан үүсгүүрийн төлбөрийг барагдуулах тухай | Дугаар 116 | 527 |

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

 2007 оны 05 дугаар
сарын 10-ны өдөр

Дугаар 37

 Улаанбаатар
хот

**Төрийн өмчөөс аймаг, нийслэлийн өмчид
эд хөрөнгө шилжүүлэх, орон нутгийн
өмчийн зарим эд хөрөнгийг төрийн
өмчид хүлээн авах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4, 77 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Төрийн өмчөөс аймаг, нийслэлийн өмчид шилжүүлэх эд хөрөнгийн жагсаалтыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг үндэслэн хоёрдугаар хавсралтад заасан эд хөрөнгийг төрийн өмчид хүлээн авахыг Монгол Улсын Засгийн газарт зөвшөөрсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА** **Ц.НЯМДОРЖ**

Монгол Улсын Их Хурлын 2007 оны
37 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

ТӨРИЙН ӨМЧӨӨС АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ӨМЧИД ШИЛЖҮҮЛЭХ ЭД ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

1. Архангай аймаг

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Эд хөрөнгийн үнэ /мян.төг/
1	Төвшрүүлэх	Дизель станцын барилга	10,960.00
	ДҮН		10,960.00

2. Баянхонгор аймаг

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Эд хөрөнгийн үнэ /мян.төг/
1	Баянхонгор-Эрдэнэцогт	Цахилгаан дамжуулах агаарын шугам /6кВ-ын, 24 км/	130,730.00
2	Баянхонгор-Шаргалжуут	Цахилгаан дамжуулах агаарын шугам /10кВ-ын, 32,25 км/	206,000.00
	ДҮН		336,730.00

3. Говь-Алтай аймаг

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Эд хөрөнгийн үнэ /мян.төг/
1	Есенбулаг	Аймгийн Талнуулын албаны хуучин барилга /гараж/	1,612.22
	ДҮН		1,612.22

4. Дорнод аймаг

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Эд хөрөнгийн үнэ /мян.төг/
1	Хэрлэн	Аймгийн Талнуулын албаны хуучин барилга /гараж, агуулах/	27,024.00
	ДҮН		27,024.00

5. Завхан аймаг

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Эд хөрөнгийн үнэ /мян.төг/
1	Улиастай-Алдархаан	Цахилгаан дамжуулах агаарын шугам /35кВ-ын, 28 км/	641,800.00
	ДҮН		641,800.00

6. Өвөрхангай аймаг

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Эд хөрөнгийн үнэ /мян.төг/
1	Арвайхээр	Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн 90 ортой хүүхдийн эмнэлгийн барилга	14,260.00
	ДҮН		14,260.00

7. Увс аймаг

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Эд хөрөнгийн үнэ /мян.төг/
1	Улаангом	Аймгийн Тагнуулын албаны хуучин барилга /гараж, төмөр хашаа, модон хашаа/	32,309.50
	ДҮН		32,309.50

8. Хөвсгөл аймаг

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Эд хөрөнгийн үнэ /мян.төг/
1	Мөрөн-Бүрэнтогтох	Цахилгаан дамжуулах агаарын шугам /10кВ-ын, 50.1 км/	233,430.00
2	Мөрөн-Түнэл	Цахилгаан дамжуулах агаарын шугам /10кВ-ын, 46.1 км/	239,700.00
	ДҮН		473,130.00

9. Улаанбаатар хот

№	Дүүргийн нэр	Эд хөрөнгийн нэр	Эд хөрөнгийн үнэ /мян.төг/
1	Баянзүрх	Цагдаагийн хотхоны дулаан, ус сувгийн байгууламжууд	162,564.40
2	Сонгинохайрхан	Хилийн цэргийн 0119 дүгээр ангийн эзэмшилд байгаа уурын зуух, гадна шугам сүлжээ	31,572.30
3	Баянзүрх	Сансар хотхоны өргөтгөлийн насос	35,590.00
4	Баянзүрх	Шар хадны 1 дүгээр хотхоны дулаан, ус сувгийн байгууламж	84,605.90
	ДҮН		314,332.60
	НИЙТ ДҮН		1,852,158.32

Монгол Улсын Их Хурлын 2007 оны 37 дугаар тогтоолын 2 дугаар хэвсрэлт

ОРОН НУТГИЙН ӨМЧӨӨС ТӨРИЙН ӨМЧИД ХҮЛЭЭН АВАХ ЭД ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

1. Архангай аймаг

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Эд хөрөнгийн үнэ /мян.төг/
1	Эрдэнэбулган	Гал түймэртэй тэмцэх хэлтэс /хуучнаар/-ийн эд хөрөнгө	186,755.70
	ДҮН		186,755.70

2. Баянхонгор аймаг

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Эд хөрөнгийн үнэ /мян.төг/
1	Баянхонгор	Газрын албаны эзэмшилд байгаа барилга	69,218.00
2	Баянхонгор	Онцгой байдлын хэлтсийн эд хөрөнгө	113,621.30
	ДҮН		182,839.30

3. Булган аймаг

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Эд хөрөнгийн үнэ /мян.төг/
1	Булган	Гал түймэртэй тэмцэх хэлтэс /хуучнаар/, Цэрэг, иргэний хамгаалалтын штаб /хуучнаар/-ын эд хөрөнгө	472,227.10
	ДҮН		472,227.10

4. Говь-Алтай аймаг

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Эд хөрөнгийн үнэ /мян.төг/
1	Есөнбулаг	Гал түймэртэй тэмцэх хэлтэс /хуучнаар/, Цэрэг, иргэний хамгаалалтын штаб /хуучнаар/-ын эд хөрөнгө	124,651.47
	ДҮН		124,651.47

5. Говьсүмбэр аймаг

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Эд хөрөнгийн үнэ /мян.төг/
1	Сүмбэр	Онцгой байдлын хэлтсийн эд хөрөнгө	154,067.30
	ДҮН		154,067.30

6. Дархан-Уул аймаг

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Эд хөрөнгийн үнэ /мян.төг/
1	Дархан	Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн эзэмшилд байгаа барилга, бусад эд хөрөнгө	22,970.30
	ДҮН		22,970.30

7. Дорнод аймаг

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Эд хөрөнгийн үнэ /мян.төг/
1	Хэрлэн	Гал түймэртэй тэмцэх хэлтэс /хуучнаар/-ийн эд хөрөнгө	230,275.41
	ДҮН		230,275.41

8. Дорноговь аймаг

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Эд хөрөнгийн үнэ /мян.төг/
1	Сайхандулаан	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4кВ-ын, 2.8 км/	4,421.89
2	Дэлгэрэх	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4кВ-ын, 5.6 км/	7,769.29
3	Улаанбадрах	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4кВ-ын, 3.08 км/	9,753.00
4	Замын-Үүд	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /нэмэлт 0.4кВ-ын, 0.72 км/, 10/04 хВ-ын 160 КВА дэд станц	7,970.70
5	Сайншанд	Онцгой байдлын хэлтсийн эд хөрөнгө	165,493.88
	ДҮН		195,408.76

9. Дундговь аймаг

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Эд хөрөнгийн үнэ /мян.төг/
1	Адаацаг	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4 кВ-ын, 8.5 км/	3,995.94
2	Баянжаргалан	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4кВ-ын, 9.35 км/	3,870.00
3	Мандалговь	Онцгой байдлын хэлтсийн эд хөрөнгө	38,662.90
4	Өлзийт	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4кВ-ын, 2 км/	11,380.10
	ДҮН		57,908.94

10. Завхан аймаг

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Эд хөрөнгийн үнэ /мян.төг/
1	Улиастай	Онцгой байдлын хэлтсийн эд хөрөнгө	142,600.00
	ДҮН		142,600.00

11. Орхон аймаг

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Эд хөрөнгийн үнэ /мян.төг/
1	Орхон	Онцгой байдлын хэлтсийн эд хөрөнгө	206,100.00
	ДҮН		206,100.00

12. Өвөрхангай аймаг

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Эд хөрөнгийн үнэ /мян.төг/
1	Арвайхээр	Онцгой байдлын хэлтсийн эд хөрөнгө	135,207.20
	ДҮН		135,207.20

13. Сүхбаатар аймаг

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Эд хөрөнгийн үнэ /мян.төг/
1	Баруун-Урт	"Сүхбаатар эрчим" орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын эд хөрөнгө	2,323,152.50
2	Баруун-Урт	Онцгой байдлын хэлтсийн эд хөрөнгө	516,693.80
3	Мөнххаан	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4 кВ-ын, 2.3 км/	1,400.00
	ДҮН		2,841,246.30

14. Сэлэнгэ аймаг

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Эд хөрөнгийн үнэ /мян.төг/
1	Сүхбаатар	Онцгой байдлын хэлтсийн эд хөрөнгө	548,494.70
	ДҮН		548,494.70

15. Төв аймаг

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Эд хөрөнгийн үнэ /мян.төг/
1	Зуунмод	Онцгой байдлын хэлтсийн эд хөрөнгө	224,675.70
	ДҮН		224,675.70

16. Увс аймаг

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Эд хөрөнгийн үнэ /мян.төг/
1	Улаангом	Онцгой байдлын хэлтсийн эд хөрөнгө	230,752.80
2	Улаангом	Газрын албаны эзэмшилд байгаа барилга	15,238.80
	ДҮН		245,991.60

17. Ховд аймаг

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Эд хөрөнгийн үнэ /мян.төг/
1	Жаргалант	Онцгой байдлын хэлтсийн эд хөрөнгө	194,628.20
2	Буянт	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0,4 кВ-ын, 4 км/	10,000.00
3	Мянгад	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0,4 кВ-ын, 7.85км/	25,385.00
4	Ховд	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0,4 кВ-ын, 1,6 км/	4,000.00
5	Эрдэнэбүрэн	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0,4 кВ-ын, 2,7 км/	6,762.50
	ДҮН		240,775.70

18. Хөвсгөл аймаг

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Эд хөрөнгийн үнэ /мян.төг/
1	Мөрөн	Гал түймэртэй тэмцэх хэлтэс /хуучнаар/-ийн эд хөрөнгө	181,556.49
	ДҮН		181,556.49

19. Хэнтий аймаг

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Эд хөрөнгийн үнэ /мян.төг/
1	Галшар	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0,4 кВ-ын, 2,4 км/	6,675.00
2	Баян-Адарга	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0,4 кВ-ын, 1,7 км/, 6,0 кВ-ын шугам 1,4 км, дэд өртөө 3 ш	8,221.80
3	Биндэр	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0,4 кВ-ын, 3,6км/, 6,0 кВ-ын шугам 2 км, дэд өртөө 4 ш	3,075.00
4	Баян-Овоо	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0,4 кВ-ын, 1,7 км/	2,800.00
	ДҮН		20,771.80
	НИЙТ ДҮН		6,414,523.77

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 05 дугаар сарын 23-ны өдөр

Дугаар 96

Улаанбаатар хот

Зэвсэгт хүчний зарим офицер, ахлагч нарыг медалиар шагнах тухай

Афганистан, Косово, Баруун Сахар тэртэй биелүүлсэн Монгол Улсын Зэвсэгт хүчний Улсуудад НҮБ-ын Энхийг сахиулах хүмүүнлэгийн цэргийн багийн дор дурдсан офицер, ахлагч нарыг олон улсын ажиллагаанд оролцож албан үүргээ нэр медалиар шагнасугай.

ЦЭРГИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Батсуурийн Эрдэнэбат - Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн сургалч багш, хошууч

"ЭНХИЙН ТОЛСӨ" МЕДАЛИАР:

1. Буянхишигийн Алтангадас - Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн буудагч, дэд ахлагч
2. Даваасүрэнгийн Алтансүх - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн механик жолооч, дэд ахлагч

3. Гэрэлчулууны Алтанхуяг - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн мэргэн буудагч, дэд ахлагч
4. Норовсүрэнгийн Атарсайхан - Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн наводчик, ахлагч
5. Цэцэгэгийн Баатар - Зэвсэгт хүчний 015 дугаар ангийн нярав засварчин, сургагч ахлагч
6. Хандхүүгийн Бат-Амгалан - Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн салааны захирагч, дэслэгч
7. Батхуягийн Батбаяр - Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн хадгалах тасгийн дарга, дэслэгч
8. Хайнзангийн Батсүх - Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн химийн дарга, хошууч
9. Чимэддоржийн Баттулга - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн буудагч, дэд ахлагч
10. Ганболдын Батцэнгэл - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн пулемётчин, дэд ахлагч
11. Энхтайваны Баярмагнай - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн механик жолооч, дэд ахлагч
12. Лувсанбазарын Басжавхлан - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн буудагч, дэд ахлагч
13. Төрмөнхийн Буянбат - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн ажиллагааны офицер, ахлах дэслэгч
14. Хашбатын Болдбат - БХЯ-ны Гадаад хамтын ажиллагааны газрын мэргэжилтэн, хошууч
15. Пүрэвийн Ганхүү - Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн буудагч, дэд ахлагч
16. Мягмардагвын Гантулга - Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн салааны захирагч, дэслэгч
17. Пүрэв Очирын Гантулга - Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн төлөвлөлтийн офицер, дэслэгч
18. Басаадайн Гүнчинсүрэн - Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн салааны захирагч, ахлах дэслэгч
19. Гэндэнбазарын Дашцэрэн - Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн станцын дарга, ахлах радиотелеграфчин, ахлагч
20. Бяруузаны Доржпүрэв - Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн засварчин жолооч, ахлах ахлагч
21. Замандийн Жамъянчагнаа - БХИС-ийн Цэргийн дээд сургуулийн багш, дэд хурандаа
22. Даваадоржийн Жаргалсайхан - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн буудагч, дэд ахлагч
23. Ганболдын Золбат - Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн наводчик, дэд ахлагч
24. Биндэрьяагийн Мөнх-Од - Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн зэвсгийн дарга, дэслэгч
25. Адъяагийн Нямхүү - Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн батарейны захирагч, дэслэгч
26. Мягмардоржийн Одбаяр - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн механик жолооч, дэд ахлагч
27. Нарантөгсийн Отгонбаатар - Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн наводчик, оператор, дэд ахлагч
28. Чимэдцэрэнгийн Очүү - Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн радиотелеграфчин, дэд ахлагч
29. Сүхбаатарын Соёхүү - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн мэргэн буудагч, дэд ахлагч
30. Гүрсэдийн Сүхбаатар - Зэвсэгт хүчний 016 дугаар ангийн артиллерийн дарга, дэд хурандаа
31. Мөнхжаргалын Төмөрбарс - Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн артиллерийн батарейны жагсаалын дарга, ахлагч
32. Ганбаярын Ууганбаяр - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн буудагч, дэд ахлагч
33. Ганжуурын Уранжаргал - Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн салааны захирагч, дэслэгч
34. Уебаатарын Хүрлээ - Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн батарейны захирагч, ахлах дэслэгч
35. Цэрэнпүрэвийн Цэрэнбат - Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн дайчилгааны офицер, хошууч
36. Базарын Цогсүрэн - Зэвсэгт хүчний 015 дугаар ангийн суурин ба хөдөлгөөнт төв засварын дарга, дэд хурандаа
37. Энхболдын Чинзориг - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн механик жолооч, дэд ахлагч
38. Сүрэнгийн Эрдэнэболор - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн наводчик, дэд ахлагч
39. Батдэлгэрийн Энхцэг - Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн салааны захирагч, дэслэгч

2007 оны 05 дугаар сарын 24-ний өдөр

Дугаар 97

Улаанбаатар хот

“Нээлттэй хаалганы өдөр”-ийг зохион байгуулж байх тухай

Монголын ард түмэн бид Үндсэн хуулиндаа тунхагласан, "...Эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх..." эрхэм зорилгыг нийгэмд ажил хэрэг болгон хэрэгжүүлэх нэг чухал нөхцөл нь төр, нийгмийн хэрэгт иргэдийг оролцуулах явдал юм. Ийм ч учраас Монгол Улсын Ерөнхийлөгч Монгол Улсын тусгаар тогтнолын тухай бүх ард түмний санал хураалтын 60 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний бага хуралд хэлсэн үгэндээ "...энэ өдрийг цаашид түүхэн энэ явдлыг дурсах, мөнхжүүлэх үүднээс төдийгүй улсынхаа тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдлаа бататгах, эх орон, бүс нутаг, нутаг орон, хот тосгодоо хөгжүүлэх арга замын тухай нээлттэй өргөн хэлэлцүүлэг, бүтээлч хөдөлгөөн өрнүүлдэг, иргэдийн саналыг засаглалын бүх төвшинд сонсох "Нээлттэй хаалганы өдөр болгох" ..." талаар санал дэвшүүлж байсан билээ.

Энэ санал, санаачилгыг олон түмний зүгээс дэмжиж байгаа байдал, түүнийг нийт нийгмийн хэмжээнд зорилго, чиглэлтэйгээр тогтмол хэрэгжүүлж байх шаардлагыг харгалзан Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дугаар заалт болон Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12 дахь заалтыг үндэслэн ЗАРЛИГ БУУЛГАХ НЬ:

1. БНМАУ-ын тусгаар тогтнолын талаархи асуудлын талаар бүх ард түмний саналыг гаргуулах тухай" БНМАУ-ын Бага хурлын Тэргүүлэгчдийн 1945 оны түүхэн шийдвэрийн дагуу Монгол Улсын тусгаар тогтнолыг баталгаажуулсан ард түмний сэнал эсуултыг явуулсан; өдрийг тохиолдуулан Засгийн газар, орон нутгийн удирдлага, тэдгээрийн харъяаны бүх шатны байгууллага, албан

тушаалтнууд бодлого боловсруулах, шийдвэр гаргахдаа иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын санал, зөвлөгөөг сонсч тусгах зорилгоор жил бүрийн 10 дугаар сарын 20-нд орон даяар "Нээлттэй хаалганы өдөр"-ийг зохион байгуулж ажиллахыг Засгийн газарт чиглэл болгосугай.

2. Бүтэн жилийн турш иргэдээс ирүүлсэн бүтээлч, ажил хэрэгч саналыг гүйцэтгэх удирдлагын байгууллагууд, холбогдох албан тушаалтан хүлээн авах, шийдвэрлэх, хэрэгжүүлэх, тэдгээрийн нийгэм, эдийн засаг, улс төрийн амьдралд үзүүлж байгаа эерэг үр дүн, үр нөлөөг нэгтгэн дүгнэж, ард түмэндээ мэдээлж байдаг эргэх холбооны тогтолцоог Засгийн газрын хэмжээнд бүрэлдүүлэн ажиллах нь зүйтэй гэж үзсүгэй.

3. Иргэдээс дэвшүүлж тавьсан санал, санаачилгыг дэмжиж хэрэгжүүлэх талаар эргэх холбооны тогтолцоо бүрдэж, тэдгээрийг дүгнэн мэдээлдэг "Нээлттэй хаалганы өдөр" буй болгож байгаатай уялдуулж өөрсдийн дэвшүүлж байгаа санал, санаачилгынхаа үр ашиг, үр нөлөө, хэрэгжих магадлал, үл үндэстэй тооцоо, судалгаа, ажил хэрэгч байдлыг дээшлүүлэхийг нийт иргэддээ зөвлөсүгэй.

4. Иргэдээс гарах санал, санаачилгыг ажил хэрэг болгох талаар гүйцэтгэх удирдлагын зүгээс авч буй арга хэмжээнүүдийг байнга сурталчлах, түгээх явдалд идэвх санаачилгатай оролцохыг нийт хэвлэл, мэдээллийн байгууллага, ажилтнуудад уриалсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ
Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД
М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 05 дугаар
сарын 24-ний өдөр

Дугаар 98

Улаанбаатар
хот

**Их эзэн Чингис хааныг дээдлэн хүндэтгэх,
зарлигласан онол сургаалиас нь суралцах, түүний хөшөө,
Төрийн ёслол хүндэтгэлийн өргөө цогцолборт
төрийн хүндэтгэл үзүүлж байх тухай**

Их Монгол Улсын төрийн гал голомтыг асаан бадруулж, аугаа их суу билиг, хүч чадлаар Монгол хэмээх нэрийг ертөнц дахинаа хүртээн дуурсгасан Их эзэн Чингис хааны алдар гавъяа хүн төрөлхтөнд мянга мянган жилээр бахдал бишрэлийг төрүүлж, үлгэр дуурал болох нь зүй билээ.

Эдүгээ цагт үндэсний хэмжээнд Их эзэн Чингис хааны байгуулсан түүхэн гавъяа зүтгэл, үйл хэрэг, оюунлаг билиг сургаалийг нь судлан сурталчлах, бишрэн дээдлэх, хүндэтгэн бахархах ажил багагүй хийгдэж байгааг цаашид ч хамрах хүрээ, эрч далайцыг нь нэмэгдүүлэх нь чухал юм.

Тархай бутархай олон овог, аймгийг нэгэн үзэл санаа, зорилгын дор нэгтгэн хүчирхэг Монгол Улсыг байгуулж, үл тасалдах төрт ёс, соёл, түүхийн баялаг уламжлалыг шинээр болон сэргээн хөгжүүлсэн, дэлхий дахинаа даяаршлын үзэл санааг бодитой үүсгэн хэрэгжүүлсэн мянганы суут хүн, төр, цэргийн нэн гарамгай зүтгэлтэн Их эзэн Чингис хааны хөшөө, Төрийн ёслол хүндэтгэлийн өргөө" цогцолборыг Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойг тохиолдуулан монголчууд бид ёслол төгөлдөр бүтээн цогцлоосон билээ. Их эзэн Чингис хааныг дээдлэн хүндэтгэх, зарлигласан онол сургаалиас нь суралцах, түүний хөшөө, Төрийн ёслол хүндэтгэлийн өргөө цогцолборт төрийн хэмжээнд хүндэтгэл үзүүлж байх нь зүйтэй гэж үзэн иртэд, иргэний нийгэм, улс төрийн намууд, төр захиргааны байгууллагуудаас тавьж буй саналыг харгалзан Үндсэн хуулийн 34 дүгээр зүйлийн 1 дэх заалтыг үндэслэн ЗАРЛИГ БУУЛГАХ НЬ:

1. Монгол Улсын Үндэсний их баяр наадам Ардын хувьсгалын ойн өдөр, Их Монгол Улс байгуулагдсаны ойн өдөр, Бүгд Найрамдах Улсыг

тунхагласны баярын өдөр, Их эзэн Чингис хааны мэндэлсэн өдөр /Билгийн тооллын зуны эхэн сарын улаан тэргэл өдөр/, Монголын уламжлалт баяр-Цагаан сарын шинийн нэгний өдөр тус тус "Их эзэн Чингис хааны хөшөө, Төрийн ёслол хүндэтгэлийн өргөө" цогцолборт төрийн хүндэтгэл үзүүлж байсугай.

2. Энэ өдрүүдэд орон даяар бүх байгууллага, хамт олон, сургууль, соёлын газрууд Эзэн богд Чингис хааны эш хөргийг залах, зарлиг, сургаалиас нь судлан суралцах, захиас гэрээсийг нь хэрэгжүүлэх чиглэлээр зохистой ажил өрнүүлж байх нь зүйтэй гэж үзсүгэй.

3. "Их эзэн Чингис хааны хөшөө, Төрийн ёслол хүндэтгэлийн өргөө" цогцолборт төрийн хүндэтгэл үзүүлэх журмыг боловсруулан мөрдөх болон энэхүү зарлигийг хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газарт чиглэл болгосугай.

4. Эзэн богд Чингис хаан эцгээ дээдлэн хүндэтгэх, зарлиг сургаалиас нь суралцах, захиас гэрээсийг нь биелүүлж, сахин дагах журамт үүргээ Их Монгол Улсын гал голомтыг өвлөн залгамжилсан эдүгээгийн Монгол Улсын иргэн бүр гүнээ ухамсарлан эх орноо шинэ мянганы хөгжил дэвшил, мандал бадралын өндөрлөгт хүргэхийн төлөө эв зөв эрхэмлэж, чин шударгаар хичээнгүйлэн хувь нэмрээ оруулахыг уриалсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ
Н.ЭНХБАЯР**

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД
М.ЭНХБОЛД**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 05 дугаар
сарын 25-ны өдөр

Дугаар 99

Улаанбаатар
хот

БНСУ-ын зарим иргэдийг одон, медалиар шагнах тухай

Монгол Улс, БНСУ-ын харилцааг үхмүүнлэгийн салбар болон монгол судлалд өргөжүүлэн хөгжүүлэх, парламент хоорондын оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж БНСУ-ын хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх, Монголын иргэн дараах хүмүүсийг одон, медалиар боловсрол, эрүүл мэнд, түүх, соёл, шагнасуугай.

"АЛТАН ГАДАС" ОДОНГООР:

- | | |
|---|---|
| 1. Ли Хан Дон - БНСУ-ын Ерөнхий сайд асан, Солонгос - Монголын харилцааг дэмжих нийгэмлэгийн Хүндэт ерөнхийлөгч | 2. Ким Ген Чхель - Сеул дэх "Улаанбаатар соёлын төв"-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн тэргүүн |
|---|---|

"НАЙРАМДАЛ" МЕДАЛИАР:

- | | |
|---|--|
| 1. Ким Сан Хен - БНСУ-ын Парламентын гишүүн, Парламент дахь Солонгос-Монголын найрамдлын бүлгийн дарга асан | 7. Ким Сөк Хо - "Сөн Ай" эмнэлгийн гүйцэтгэх захирал |
| 2. Ю Хэ Гын - Сеул дэх Монгол сургуулийн Төлөөлөн удирдах зөвлөлийн тэргүүн | 8. Чой Ги Хо - "Санмен" их сургуулийн Багшийн сургуулийн захирал, монгол судлаач |
| 3. Жо Бөм Гү - БНСУ-ын НХЭМЯ-ны Эрүүл мэндийн улсын даатгалын хяналтын агентлагийн дарга | 9. Кан Шин - "Дангуг" их сургуулийн Монгол хэлний тэнхмийн эрхлэгч |
| 4. Ан Мин Дон - "Ротари" клубын 3740 дүгээр тойргийн Ерөнхийлөгч асан | 10. Мүүн Ен Шиг - Монгол-Солонгосын Дорнын анагаах ухааны төвийн эмч, доктор |
| 5. Ю Ен Гю - "Мёнжи" их сургуулийн Төлөөлөн удирдах зөвлөлийн тэргүүн | |
| 6. Жөн Ен Ги - "Жэжү мейжик уолд" компанийн ерөнхий захирал | |

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 05 дугаар
сарын 25-ны өдөр

Дугаар 100

Улаанбаатар
хот

Дэмбэрэлийн Чойжамцад Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Монгол Улсын шинэ Үндсэн хуулийг батлалцан, Монголын уламжлалт шашины соёл, ёс заншлыг сэргээн хөгжүүлж, Монголын бурхны шашинтны төв Гандантэгчэнлин хийдийн үйл ажиллагааг өргөжүүлэх, гадаад харилцааг хөгжүүлэх, сүсэгтэн олонд хүмүүнлэг нигүүлсэнгүй үзэл санааг түгээн дэлгэрүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг үнэлж Монголын бурхны шашинтны төв Гандантэгчэнлин хийдийн тэргүүн их хамба, гавж Дэмбэрэлийн Чойжамцад Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 05 дугаар сарын 25-ны өдөр

Дугаар 101

Улаанбаатар хот

Чойжилжавын Дамбажавт Монгол Улсын соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Монголын бурхны шашны байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж, сүсэгтэн олны эрэлт хүсэлтэд нийцсэн сүм, хийдийг үүсгэн байгуулж, үйл ажиллагааг үндэсний түүх, соёл, ёс заншил, уламжлалаа сэргээх болон нийгэм, хүмүүнлэгийн ажилд чиглүүлж, олон улсын буддын шашинтны болон шашин хоорондын хамтын

ажиллагааг өргөжүүлэн бэхжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг үнэлж Дашчойлон хийдийн тэргүүн хамба Чойжилжавын Дамбажавт Монгол Улсын соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 05 дугаар сарын 28-ны өдөр

Дугаар 124

Улаанбаатар хот

Зарим хүмүүсийг сум дундын шүүхийн ерөнхий шүүгчийн албан тушаалд томилуулах тухай

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 12 дугаар зүйлийн 16, "Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 32 дугаар зүйлийн 32.4 дэх хэсгийг тус тус баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:
Даваасүрэнгийн Ариунцэцэгийг Орхон аймаг дахь сум дундын шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчийн,

Дашдэлэгийн Гэнзоригийг Хэнтий аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн ерөнхий шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 05 дугаар сарын 28-ны өдөр

Дугаар 125

Улаанбаатар хот

Зарим хүмүүсийг шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 9 дүгээр зүйлийн 1, "Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 58 дугаар зүйлийн 58.1.2, 58.1.4 дэх хэсгийг тус тус баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

шүүхийн шүүгчийн, Шаравын Баттогтохыг Говь-Алтай аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Цээлийн Амаржаргалыг Ховд аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн, хуульд заасан тэтгэвэр тогтоологх насанд хүрсэн тул Даахарын Цэрэнпилийг Нийслэлийн Баянгол дүүргийн шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

Төрийн өөр ажил, албан тушаалд томилогдох болсон тул Даваасүрэнгийн Ариунцэцэгийг Орхон аймгийн шүүхийн шүүгчийн, Маруушийн Хүрэлбаатарыг Говь-Алтай аймгийн

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 05 дугаар сарын 28-ны өдөр

Дугаар 126

Улаанбаатар хот

Зарим хүмүүсийг аймаг, сум дундын болон нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн шүүгчийн албан тушаалд томилуулах тухай

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 12 дугаар зүйлийн 16, "Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсгийг тус тус баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Маруушийн Хүрэлбаатарыг Булган аймгийн шүүхийн шүүгчийн, Шаравын Баттогтохыг Говь-Алтай аймгийн шүүхийн шүүгчийн, Цэлийн Амаржаргалыг Сэлэнгэ аймгийн шүүхийн шүүгчийн, Лхагвасүрэнгийн Дарьсүрэнг Булган аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Намхайдоржийн

Оюунбилэгийг Говь-Алтай аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Намсрайн Батзоригийг Орхон аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Цэдэвийн Отгонжаргал, Мягмарын Пагма-Оролмаа, Рагчаагийн Үүрийнтуяа нарыг Увс аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Кадирбекийн Бүлдиренгийг Баян-Өлгий аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 05 дугаар сарын 28-ны өдөр

Дугаар 127

Улаанбаатар хот

Шүүгчийг сэлгэн ажиллуулах тухай

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 9 дүгээр зүйлийн 1, "Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсгийг тус тус баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Говьсүмбэр аймаг дахь сум дундын

шүүхийн шүүгч Очирбатын Номуулинг Нийслэлийн Баянгол дүүргийн шүүхийн шүүгчийн албан тушаалд сэлгэн ажиллуулсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 05 дугаар сарын 28-ны өдөр

Дугаар 128

Улаанбаатар хот

T.Эрдэнэбаатарыг шүүгч, ерөнхий шүүгчийн албан тушаалаас огцруулах тухай

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 9 дүгээр зүйлийн 1, "Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1 дэх хэсгийг тус тус баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь: Шүүгчээс огцруулах тухай Сахилгын хорооны шийдвэр хүчин төгөлдөр болсон тул

Түндэвийн Эрдэнэбаатарыг Өвөрхангай аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчийн албан тушаалаас огцруулсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2007 оны 03 дугаар сарын 14-ний өдөр

Дугаар 61

Улаанбаатар хот

Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:
1. Засгийн газрын 2006 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн 110 дугаар тогтоолоор батлагдсан "Шувууны томууны цартахлаас сэргийлэх, тэмцэх үндсэн чиглэл"-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.

2. Төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн сайд Д.Туяа, Хүнс, хөдөө аж ахуйн

сайд Д.Тэрбишдагва, Монгол Улсын сайд С.Отгонбаяр нарт даалгаж, шаардагдах санхүүжилтийг Дэлхийн банк болон бусад хандивлагчдад хандан шийдвэрлэхийг Сангийн сайд Н.Баяртсайханд зөвшөөрсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН САЙД С.ОТГОНБАЯР

“ШУВУУНЫ ТОМУУНЫ ЦАРТАХЛААС СЭРГИЙЛЭХ, ТЭМЦЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ”-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Арга хэмжээ		Хариуцах байгууллага	Хамтран ажиллах байгууллага	Хугацаа
1. Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах асуудлаар				
1.1. Малын эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх талаар	1. Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар мал эмнэлгийн албаны бүтэц, тогтолцоог боловсронгуй болгох	ХХААЯ	УМХГ, аймаг нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар	2007
	2. Мал эмнэлгийн анхан шатны байгууллагын үйлчлэлтэй дэмжих замаар чанар, хүртээмжийг сайжруулах	ХХААЯ	Аймаг, нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар	2007-2009
1.2. Зэрлэг шувуудын дунд танадалт судалгаа хийх	1. Гоц халдварт өвчин, түүний дотор шувууны томууг оношлох олон улсын стандартын шаардлага хангасан, аюулгүй байдлын III зэрэглэлийн лаборатори байгуулах, аймаг, орон нутагт лабораторийн оношилгооны чадавхийг дээшлүүлэх	ХХААЯ	Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори, аймаг, нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар	2007-2009
	2. Зэрлэг шувуудын дунд өндөр хоруу чанартай вирусийг танадах үйл ажиллагааг зохион байгуулах, мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох	ХХААЯ	УМХГ, Мал эмнэлгийн хүрээлэн, Биологийн хүрээлэн, Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори, Байгалийн судлалын үндэсний төв	2007-2008
3. Зэрлэг шувуудын дунд эргэлдэж байгаа өндөр хоруу чанартай H5N1 вирусийг илрүүлэх танадалтын хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх, өвчнийг эрт илрүүлэх, хариу арга хэмжээ шуурхай авах	3. Зэрлэг шувуудын дунд эргэлдэж байгаа өндөр хоруу чанартай H5N1 вирусийг илрүүлэх танадалтын хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх, өвчнийг эрт илрүүлэх, хариу арга хэмжээ шуурхай авах	ХХААЯ	Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори, Биологийн хүрээлэн, Мал эмнэлгийн хүрээлэн, Байгалийн голомтот халдварт өвчин судлалын үндэсний төв	2007-2009
	4. Зэрлэг шувуудын дунд томуугийн H5N1 вирусээр үүсгэгдсэн өвчин гарсан үед авч хэрэгжүүлэх бэлэн байдлын төлөвлөгөө боловсруулах	ХХААЯ	ОБЕГ, УМХГ, Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори	2007-2008

	2. Хүний томуугийн цэртахал гарсан үед Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах 3. Цар тахлын үед хүнс, хөдөө аж ахуйн салбараас авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах	ХХААЯ ХХААЯ	УМХГ Аймаг, нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар	2007-2008 2007-2009
2.1. Эрүүл мэндийн тогтолцооны чадвархийг дээшлүүлэх талаар	2. Хүний эрүүл мэндийг хамгаалах асуудлаар 1. Ариутгал, халдваргүйтлийн бодис, гар угаах бодисуудыг хангах замаар эрүүл мэндийн байгууллагын халдвар эсэргүүцэх чадвархийг сайжруулах 2. Амбулаторийн өвчтөнд үзүүлэх үйлчилгээг сайжруулах (түргэн тусламжийн машин, бусад тоног төхөөрөмж г.м.) 3. Вакцин хадгалах, тээвэрлэх, түгээх хүйтэн хэлхээний системийн чадвархийг сайжруулах (Төөлөлн болон цэртахлын вакцин) 4. Аймгийн түвшинд томуу, томуу тест өвчнийг оношлох лабораторийн хүчин чадлыг бэхжүүлэх 5. Халдварт өвчин судлалын үндэсний төв болон Байгалийн голомтот халдварт өвчин эмгэг судлалын төвийн лабораторийн био-аюулгүйн нөхцөлийг сайжруулах 6. Зарим аймгийн эмнэлгийн тусгаарлах өрөөг тоноглох 7. Хилийн томоохон боомтуудын эмнэлгийг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах 1. Томуу, томуу тест өвчнийг эрт илрүүлэх, хэриу арга хэмжээ авах тандалтын тогтолцоог бэхжүүлэх 2. Эмнэлэг, өрхийн эмнэлгүүдэд тулгуурлан лабораторид суурилсан томуу тест өвчний тандалт, хяналтын тогтолцоог бэхжүүлэх 3. Сорьц тээвэрлэх "Сум-Аймаг-Халдварт өвчин судлалын үндэсний төв-Олон улсын лавлагаа" гэсэн лабораторийн тогтолцоог байгуулах	ЭМЯ ЭМЯ ЭМЯ ЭМЯ ЭМЯ ЭМЯ ЭМЯ ЭМЯ ЭМЯ ЭМЯ	УМХГ Халдварт өвчин судлалын үндэсний төв, Байгалийн голомтот халдварт өвчин эмгэг судлах төв УМХГ УМХГ Халдварт өвчин судлалын үндэсний төв, Байгалийн голомтот халдварт өвчин эмгэг судлах төв Халдварт өвчин судлалын үндэсний төв Халдварт өвчин судлалын үндэсний төв Халдварт өвчин судлалын үндэсний төв Халдварт өвчин судлалын үндэсний төв УМХГ, аймгийн Эрүүл мэндийн газар	2007-2009 2007-2009 2007-2009 2007-2009 2007-2009 2007-2009 2007-2009 2007-2009

	1. Тамифлю эмийг нийлүүлэх, түгээх	ЭМЯ	Халдварт өвчин судлалын үндэсний төв, Байгалийн голомтот халдварт өвчин эмгэг судлах төв	2007-2009
2.3. Эрүүл мэндийн салбарын томоутай тэмцэх арга хэмжээний талаар	2. Өөрийгөө хамгаалах хувцас, хэрэгслийг зөв хэрэглэх, хадгалах талаар сургалт зохион байгуулах 3. Улирлын чанартай томиугийн вакцинаар эрсдэлт бүлгийн хүн амыг дархлаажуулах	ЭМЯ	УМХГ	2007-2009
	4. Томуугийн дэгдэлтийн үед эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах	ЭМЭ	Халдварт өвчин судлалын үндэсний төв, Халдварт өвчин судлалын үндэсний төв, Байгалийн голомтот халдварт өвчин эмгэг судлах төв	2007-2009
	5. Эрүүл мэндийн салбарын бэлэн байдлыг шалгах үзүүлэх сургалт зохион байгуулах	ЭМЭ	Халдварт өвчин судлалын үндэсний төв, Байгалийн голомтот халдварт өвчин эмгэг судлах төв	2008-2009
2.4. Урьдчилан сэргийлэх, тархалтыг хягаарлах талаар	1. Томуугийн дэгдэлтийн эрт сэрэмжлүүлэг, хариу арга хэмжээ, тархвар зүйн тандалтын талаар сургалт зохион байгуулах 2. Өвчний голомтын халдвар эсэргүүцэх арга хэмжээнд хэрэглэх (голомтод, ажиглаж буй хүмүүст зориулсан) хамгаалах хувцас, яаралтай тусламжийн хайрцаг бэлтгэн түгээх	ЭМЭ	Халдварт өвчин судлалын үндэсний төв, Байгалийн голомтот халдварт өвчин эмгэг судлах төв	2007-2009
2.5. Сургалт, эрүүл мэндийн сурталчилгааны талаар	1. Тэжээвэр шувуу, шувууны томиугийн вирус хүний дунд өвчлөл үүсгэх болон томиугийн цартахлын талаар мэдээлэл, сургалт, сурталчилгааны материалуудыг болгосруулах 2. Мэдээлэл, сургалт, сурталчилгааны материалыг хэвлэн олон нийтэд түгээх	ЭМЯ	УМХГ	2007-2009
		ЭМЯ	УМХГ	2007-2009

3. Онцгой үеийн удирдлага, зохицуулалтын асуудлаар

<p>3.1. Цартахлаас сэргийлэх, тэмцэх, бэлэн байдалаас хангах талаар яамд, тэмцэх талаар яамд, байгууллагуудын нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх</p>	<p>1 Цартахлаас сэргийлэх, тэмцэх, бэлэн байдлыг хангах талаар холбогдох яам, байгууллагуудын төлөвлөгөө, нийгмийн үндсэн ажил, үйлчилгээг тасралтгүй үзүүлэх, бизнесийг тасралтгүй үргэлжлүүлэх төлөвлөгөөг боловсруулахад дэмжлэг үзүүлэх, сургалт зохион байгуулах</p> <p>2 Цартахлын бэлэн байдал, түүнтэй тэмцэх, төлөвлөгөөнүүдийг нарийвчлан гаргах, эмзэг байдлын судалгаа явуулах</p> <p>3 Гэмшгийн бэлэн байдал, онцгой байдлын үед авах арга хэмжээний төлөвлөгөөг шалгаж үнэлэх төрөл бүрийн дасгал, сургууль зохион байгуулах</p>	<p>ОБЕГ</p> <p>ОБЕГ</p> <p>ОБЕГ</p> <p>ОБЕГ</p> <p>ОБЕГ</p> <p>ОБЕГ</p>	<p>Холбогдох яам, байгууллагууд (багийн түвшинд хүртэл)</p> <p>Холбогдох яамд</p> <p>Бүх яам, байгууллага</p> <p>Аймгийн онцгой байдлын хэлтсүүд</p> <p>Аймгийн онцгой байдлын хэлтсүүд</p> <p>Аймгийн онцгой байдлын хэлтсүүд</p> <p>Холбогдох яамд</p>	<p>2007-2009</p> <p>2008</p> <p>2007-2009</p> <p>2008-2009</p> <p>2009</p> <p>2007-2009</p> <p>2008</p>
<p>3.2. Цартахлаас сэргийлэх, тэмцэх, бэлэн байдлыг хангах төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай чадвар, дэд бүтцийг хөгжүүлэх</p>	<p>1 Харилцаа холбооны зориулалтын хэрэгслээр хангах</p> <p>2 Улс, аймгийн хэмжээний онцгой байдлыг мэдээлэх тогтолцоог (24 цагийн туршид ажиллах угсан холбоо) өргөтгөн зохион байгуулах</p> <p>3 Төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэхэд туслах зорилгоср гадаадын зөвлөх ажиллуулах, гадаад орнуудын туршлагаас суралцах</p> <p>4 Шувууны томуу, томууны цартахлын үед хорио цээр тогтоосон газарт амлалж ариутгал халдваргүйжүүлэлтийн зөвөрийн байгууламжаар хангах</p>	<p>ОБЕГ</p> <p>ОБЕГ</p> <p>ОБЕГ</p> <p>ОБЕГ</p> <p>ОБЕГ</p> <p>ОБЕГ</p>	<p>Холбогдох яамд</p> <p>Холбогдох яамд</p> <p>Холбогдох яамд</p> <p>Холбогдох яамд</p> <p>Холбогдох яамд</p> <p>Холбогдох яамд</p> <p>Холбогдох яамд</p>	<p>2007-2009</p> <p>2008</p> <p>2007-2009</p> <p>2008-2009</p> <p>2009</p> <p>2007-2009</p> <p>2008</p>

<p>3.3. Шуууны томууны талаар мэдээ цуглуулах, боловсруулах, мэдээллийн тогтолцоо бүрдүүлэх</p>	<p>1. Онцгой байдлын ерөнхий газраас мэдээ авч, улсын хэмжээнд нэгтгэж, дүн шинжилгээ хийдэг гамшгийн мэдээ цуглуулах, мэдээлэх урсгалыг хянах удирдлагын мэдээллийн бүтэц бий болгох</p> <p>2. Улс, аймгийн хэмжээний онцгой байдлын мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх</p> <p>3. Улс, аймаг, сум, багийн түвшинд мэдээ цуглуулахад оролцох байгууллага, хувь хүмүүсийг сургах, үнэлгээ өгөх, мэдээлэх маягтыг стандартчилах</p>	<p>ОБЕГ</p> <p>ОБЕГ</p> <p>ОБЕГ</p>	<p>Аймгийн онцгой байдлын хэлтсүүд</p> <p>Аймгийн онцгой байдлын хэлтсүүд</p> <p>Аймгийн онцгой байдлын хэлтсүүд, Стандартчилал, хэмжил зүйн төв</p> <p>Холбогдох байгууллагууд</p>	<p>2007</p> <p>2007-2009</p> <p>2007-2009</p> <p>2007-2008</p>
<p>3.4. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хянах, үнэлэх тогтолцоог бүрдүүлэх</p>	<p>1. Төлөвлөгөөг хянах, үнэлэх тогтолцоог мэдээ боловсруулах хүчин чадалд тохируулан бий болгох</p> <p>2. Холбогдох яам, байгууллагуудтай төлөвлөгөөний хяналт, үнэлгээний талаар зөвлөлдөх уулзалт зохион байгуулах</p> <p>3. Төлөвлөгөөний явц, үр дүнд үнэлгээ хийх</p>	<p>ОБЕГ</p> <p>ОБЕГ</p> <p>УМХГ, ОБЕГ</p>	<p>Холбогдох байгууллагууд</p> <p>Холбогдох яам, агентлагууд</p> <p>Гадаадын экспертүүд</p>	<p>2007-2008</p> <p>2007-2008</p> <p>2007-2009</p>
<p>3.5. Шуууны томуу, томууны цэртахлын холбогдолтой үйл ажиллагааг орон нутгийн гамшгийн удирдлагыг дэмжих ажиллагаатай уялдуулах</p>	<p>1. Сургагч багш нарт (Засаг даргын Тамгын газрын дарга, олон нийттэй харилцах ажилтнууд) зориулсан сургалтын төлөвлөгөөнд шувууны томууны талаархи сургалтыг нэмж оруулах</p> <p>2. Төлөвлөгөөг бусад төсөд, хөтөлбөрүүдтэй уялдуулах</p>	<p>ОБЕГ</p> <p>ОБЕГ</p>	<p>Холбогдох байгууллагууд</p> <p>Холбогдох байгууллагууд</p>	<p>2008</p> <p>2008-2009</p>

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2007 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр

Дугаар 92

Улаанбаатар хот

Эрүүл мэндийг дэмжих сангийн дүрэм, сангийн зөвлөлийн бүрэлдэхүүн, зөвлөлийн ажиллах журам батлах тухай

Тамхины хяналтын тухай хуулийн 10.6, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 26.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. Эрүүл мэндийг дэмжих сангийн дүрмийг 1 дүгээр, сангийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг 2 дугаар, зөвлөлийн ажиллах журмыг 3 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.
2. Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг жил бүр улсын төсөвт тусган санхүүжүүлж байхыг

Сангийн сайд Н.Баяртсайхан, сангийн үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн сайд Д.Туяа нарт тус тус үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

М.ЭНХБОЛД

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

Д.ТУЯА

Засгийн газрын 2007 оны 92 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ САНГИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5.4.21-д заасан Эрүүл мэндийг дэмжих сан (цаашид "сан" гэх)-ийн хөрөнгийг зарцуулах, хяналт тавих, тайлагнах харилцааг зохицуулахад, эрүүл мэндийг дагаж мөрдөнө.

1.2. Сангийн хөрөнгө нь Тамхины хяналтын тухай хуулийн 10.5, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21.2-т заасан зориулалтаар зарцуулна.

1.3. Сангийн үйл ажиллагаа нь Засгийн газрын тусгай сангийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцсэн байна.

1.4. Сангийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил үйлчилгээний гүйцэтгэгчийг шалгаруулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг удирдлага болгоно.

Хоёр. Сангийн эх үүсвэр

2.1. Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгө нь дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

-улсын төсвийн хөрөнгө;

-гадаад улс, олон улсын байгууллага, түүнчлэн гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс өгсөн буцалтгүй тусламж, хандив;

-гадаад улс, олон улсын байгууллагаас Засгийн газрын шугамаар илгээсэн зээл;

-тамхины онцгой албан татварын 2 хувьтай тэнцэх хөрөнгө.

Гурав. Сангийн удирдлага, зохион байгуулалт

3.1. Сангийн удирдлага нь орон тооны бус Сангийн зөвлөл байх бөгөөд сангийн өдөр тутмын үйл ажиллагааг эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын холбогдох нэгж хариуцан гүйцэтгэнэ.

Дөрөв. Сангийн хөрөнгийг зарцуулах нөхцөл

4.1. Сангийн хөрөнгийг дор дурдсан арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна:

4.1.1. эрүүл мэндийг дэмжих төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх;



4.1.2. тамхи, архины хор хөнөөлтэй тэмцэх талаар мэдээлэл, сургалт, сурталчилгаа явуулах, хяналт тавих;

4.1.3. тамхи, архинаас үүдэлтэй өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх;

4.1.4. тамхи, архинаас гаргах эмчилгээ болон түүнд шаардлагатай эм, хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлэх;

4.1.5. тамхи, архины хэрэглээнээс хүн амын эрүүл мэнд, эдийн засагт учрах хор холбогдлыг судлах;

4.1.6. архинд донтох өвчтэй хүнд үзүүлэх эрүүл мэнд, нийгмийн халамж үйлчилгээг боловсронгуй болгох, хүртээмжийг нэмэгдүүлэх;

4.1.7. архидан согуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцож үр дүнд хүрсэн төрийн бус байгууллага, хуулийн этгээд, иргэдийн үйл ажиллагааг дэмжих;

4.1.8. хүн амын эрүүл мэндийг хамгаалах бусад үйл ажиллагааг дэмжих.

4.2. Сангаас эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр хөрөнгө гаргана.

4.3. Тухайн санхүүгийн жилд зарцуулагдаагүй Сангийн хөрөнгийн үлдэгдлийг дараа жилийн төсөв дээр нэмж батлуулна.

Тав. Сангийн гүйцэтгэлийг тайлагнах, тавих хяналт

5.1. Сангийн зарцуулалтын тайланг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 30.1-д заасны дагуу хагас, бүтэн жилээр гаргана.

5.2. Төрийн аудитын байгууллага сангийн зарцуулалтын тайланд Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу аудит хийж, дүгнэлт гаргана.

5.3. Эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага сангийн хөрөнгийн зарцуулалтын жилийн эцсийн тайланг аудитын дүгнэлтийн хамт тайлан гарснаас хойш 20 хоногийн дотор хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ.

Засгийн газрын 2007 оны 92 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ САНГИЙН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга:

-Эрүүл мэндийн сайд

Орлогч дарга:

-Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга

Гишүүд:

-Сангийн яамны Төсвийн бодлого, зохицуулалтын газрын дарга;

-Эрүүл мэндийн яамны Эрүүл мэндийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга;

-Эрүүл мэндийн яамны Санхүү, эдийн засгийн газрын дарга;

-Улсын мэргэжлийн хяналтын газрын Эрүүл мэндийн албаны дарга;

-Нийгмийн эрүүл мэндийн мэргэжлийн зөвлөлийн дарга /тохиролцооноор/;

-Монголын нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн нийгэмлэгийн гүйцэтгэх захирал /тохиролцооноор/;

-Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн ерөнхийлөгч /тохиролцооноор/.

Нарийн бичгийн дарга:

-Эрүүл мэндийн яамны эрүүл мэндийг дэмжих асуудал хариуцсан мэргэжилтэн

Засгийн газрын 2007 оны 92 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ САНГИЙН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

бүрэлдэхүүнтэй, орон тооны бус сангийн зөвлөл (цаашид "зөвлөл" гэнэ) байна.

1.1. Эрүүл мэндийг дэмжих сангийн үйл ажиллагааг удирдах байгууллага нь 9 хүний

1.2. Зөвлөл нь үйл ажиллагаандаа Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, нийгмийн эрүүл

мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, холбогдох бусад хууль тогтоомж болон энэхүү журмыг удирдлага болгоно.

Хоёр. Зөвлөлийн удирдлага, зохион байгуулалт

2.1. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь зөвлөлийг тэргүүлэх бөгөөд зөвлөлийн саналыг үндэслэн сангийн хөрөнгийг захиран зарцуулах шийдвэр гаргана. Зөвлөлийн даргын эзгүйд зөвлөлийн хурлыг зөвлөлийн орлогч дарга удирдана.

2.2. Зөвлөлийн ажлын албаны үүргийг эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын холбогдох нэгж гүйцэтгэнэ.

2.3. Сангийн зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хурал байх бөгөөд улиралд нэгээс доошгүй удаа хуралдана. Зөвлөлийн гишүүдийн гурвны хоёр хувь нь оролцсоноор хурлыг хүчинтэйд тооцно.

2.4. Зөвлөл нь сангийн санхүүгийн болон бусад үйл ажиллагаатай холбоотой асуудлыг хэлэлцэн зөвлөмж гаргана. Асуудлыг оролцсон гишүүдийн дөрөвний гурвын саналээр шийдвэрлэнэ. Хурлын тэмдэглэлийг зөвлөлийн нарийн бичгийн дарга хөтлөх бөгөөд уг тэмдэглэлд хурлын дарга гарын үсэг зурна.

2.5. Тухайн хурлаар хэлэлцэх асуудлаар зөвлөлийн гишүүн нь ашиг сонирхлын зөрчилтэй бол хуралд санал өгөх эрхгүй орох буюу хуралд оролцохгүй.

Гурав. Зөвлөлийн бүрэн эрх

3.1. Сангийн зөвлөл нь дараахь үүрэг хүлээнэ:

3.1.1. сангийн хөрөнгийн төлөвлөлтийн талаар эрүүл мэнд болон санхүүгийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад саналаа тавих;

3.1.2. сангийн хөрөнгийн орлого, зарлагын байдлад хяналт тавих, шаардлагатай

тохиолдолд холбогдох эрх бүхий байгууллагад санал тавьж шийдвэрлүүлэх;

3.1.3. сангийн хөрөнгийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээг идэвхжүүлэх;

3.1.4. сангийн үйл ажиллагаа болон сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх арга хэмжээний жилийн төлөвлөгөө, төсвийг хэлэлцэн батлах;

3.1.5. сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх эрүүл мэндийг дэмжих төсөл, хөтөлбөрийн талаар санал өгөх;

3.1.6. сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих үйл ажиллагаанд төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог хангах;

3.1.7. сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх.

3.2. Сангийн зөвлөл дараахь эрх эдэлнэ:

3.2.1. сангийн хөрөнгөөр санхүүжүүлж байгаа арга хэмжээ, төсөл, хөтөлбөрийн явц, үр дүнгийн талаархи тайланг хэлэлцэн дүгнэлт өгөх;

3.2.2. сангийн үйл ажиллагааны үр дүнг сайжруулах асуудлаар зөвлөмж гаргах;

3.2.3. сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих, илэрсэн эерчил дутагдлыг арилгах талаар үүрэг даалгавар өгөх;

3.2.4. сангийн үйл ажиллагааны тайлан, үр дүн, холбогдох мэдээ, мэдээлэл, судалгааг мэргэжлийн байгууллагаас гаргуулан авах;

3.2.5. олон улсын байгууллага, гадаад, дотоодын төрийн болон төрийн бус байгууллага, бусад сантай хамтран ажиллах;

3.2.6. сангийн хөрөнгийг зориулалт бусаар ашигласан байгууллага, иргэдэд зохих хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэх асуудлаар холбогдох байгууллагад санал оруулж шийдвэрлүүлэх.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2007 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр

Дугаар 100

Улаанбаатар хот

Ажилд томилох тухай

Засгийн газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 8 дахь хэсэг, Төрийн албаны зөвлөлийн саналыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Цэрэндуламын Шийрэвдамбыг Байгаль орчны яамны Төрийн нарийн бичгийн

даргаар томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**
М.ЭНХБОЛД
**БАЙГАЛЬ ОРЧНЫ
САЙД**
И.ЭРДЭНЭБААТАР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2007 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр

Дугаар 102

Улаанбаатар хот

Зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчний тархалтыг бууруулах ажлыг эрчимжүүлэх тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 7.1.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хүн амын өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгаан болж байгаа зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчний тархалтыг бууруулах, тэдгээрт нөлөөлөгч эрсдэлт хүчин зүйлийг илрүүлэх, өвчтөнийг эмнэлгийн хяналтад авах, амбулаториор эрт эмчлэн эрүүлжүүлэх замаар Эрүүл мэндийн даатгалын санд учрах эрсдэлийг бууруулахад чиглэсэн арга хэмжээг улсын хэмжээнд зохион байгуулж үр дүнг 2008 оны 6 дугаар сард Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Эрүүл мэндийн сайд Д.Туяад үүрэг болгосугай.

2. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэхэд шаардагдах 5.310 (таван тэрбум гурван зуун арван сая) сая төгрөгийг Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9.3-т заасан Эрүүл мэндийн даатгалын сангийн болзошгүй эрсдэлийн нөөцөөс гаргах асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлэхийг Сангийн сайд Н.Баяртсайхан, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Д.Дэмбэрэл, Эрүүл мэндийн сайд Д.Туяа нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**
М.ЭНХБОЛД
САНГИЙН САЙД
Н.БАЯРТСАЙХАН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД
Д.ТУЯА
**НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,
ХОДӨЛМӨРИЙН САЙД**
Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

 2007 оны 05 дугаар
сарын 02-ны өдөр

Дугаар 105

 Улаанбаатар
хот

Ажилд томилох тухай

Засгийн газрын тухай хуулийн 18 дугаар даргаар томилсугай.

 зүйлийн 8 дахь хэсэг, Төрийн албаны зөвлөлийн саналыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас
ТОГТООХ нь:

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**
М.ЭНХБОЛД

 Гунгаагийн Баясгаланг Хууль зүй,
дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД**
Д.ОДБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

 2007 оны 05 дугаар
сарын 02-ны өдөр

Дугаар 106

 Улаанбаатар
хот

Ажилд томилох тухай

Засгийн газрын тухай хуулийн 18 дугаар даргаар томилсугай.

 зүйлийн 8 дахь хэсэг, Төрийн албаны зөвлөлийн саналыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас
ТОГТООХ нь:

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**
М.ЭНХБОЛД

 Бямбаагийн Батсэрээдэнийг Эрүүл
мэндийн яамны Төрийн нарийн бичгийн

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД
Д.ТУЯА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

 2007 оны 05 дугаар
сарын 16-ны өдөр

Дугаар 116

 Улаанбаатар
хот

Нарны цахилгаан үүсгүүрийн толбөрийг барагдуулах тухай

 Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ
нь:

 аймаг, нийслэлийн Засаг дарга нарт
даалгасугай.

 Япон Улс болон БНХАУ-ын буцалтгүй
тусламжийн хөрөнгөөр малчдад зээлээр
нийлүүлсэн нарны цахилгаан үүсгүүрийн
хавсралтад дурдсан барагдуулаагүй байгаа
толбөрийг 2007 оны П улиралд багтаан улсын
төсөвт төвлөрүүлэх арга хэмжээ авахыг

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**
М.ЭНХБОЛД
САНГИЙН САЙД
Н.БАЯРТСАЙХАН
**ТҮЛШ, ЭРЧИМ
ХҮЧНИЙ САЙД**
Б.ЭРДЭНЭБАТ

Засгийн газрын 2007 оны 116 дугаар
тогтоолын хавсралт

ЯПОН УЛС БОЛОН БНХАУ-ЫН БУЦАЛТГИЙ ТУСЛАМЖААР МАЛЧДАД ЗЭЭЛЭЭР
НИЙЛҮҮЛСЭН ТӨЛБӨРИЙГ НЬ БАРАГДУУЛААГУЙ БАЙГАА НАРНЫ ЦАХИЛГААН
ҮҮСГҮҮРИЙН ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ

№	Аймгийн нэр	Аймгуудад нийт нийлүүлсэн нарны цахилгаан үүсгүүрийн тоо (ширхэг)					Төлбөрийг нь барагдуулаагүй байгаа нарны цахилгаан үүсгүүрийн төлбөр (төгрөг)	
		62 Вт	75 Вт	50 Вт	20 Вт	Нийт		
		1	Архангай	220	175	1180		
2	Баян-Өлгий	808	600	1200	400	3008	548.380.000	
3	Баянхонгор	1730	24	669	407	2830	359.530.000	
4	Булган	500	10	500	-	1010	11.704.000	
5	Говь-Алтай	1800	50	1100	100	3050	114.350.000	
6	Дорноговь	125	20	200	80	425	3.105.000	
7	Дорнод	100	100	460	90	750	13.322.000	
8	Дундговь	10	175	855	159	1199	18.530.000	
9	Завхан	600	125	1550	442	2717	177.654.000	
10	Өвөрхангай	296	350	940	400	1986	161.427.000	
11	Өмнөговь	120	50	400	250	820	13.312.000	
12	Сүхбаатар	1000	20	1050	230	2300	118.625.000	
13	Сэлэнгэ	108	75	110	115	408	26.558.000	
14	Төв	50	30	100	20	200	1.801.000	
15	Увс	500	250	650	100	1500	94.645.000	
16	Ховд	2208	142	862	200	3412	195.733.000	
17	Хөвсгөл	750	225	685	370	2030	106.422.000	
18	Хэнтий	-	84	540	50	674	83.205.000	
19	Дархан-Уул	100	-	-	-	100	5.204.000	
20	Орхон	50	-	50	50	150	1.938.000	
21	Говьсүмбэр	20	10	50	30	110	2.257.000	
22	Улаанбаатар (Багануур)	-	-	40	10	50	4.880.000	
23	Бүгд	11095	2515	13191	3948	30749	2.327.526.000	

 Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.

 Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.

 Улаанбаатар-12
Төрийн ордон

 ☎ 265958
Индекс 14003

Хэвлэлийн хуудас 3

☎ 325487